



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор аймаг 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mm</p> <p>Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: TseenyamA@audit.gov.mm</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг Altantuyam@audit.gov.mm</p> <p>Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: dorjkhndl@audit.gov.mn</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудитын санал дүгнэлт /эх хувь/	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт	16
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Албан шаардлага.....	17
4.2. Аудитын зөвлөмж	18
Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/64

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч нь тодорхойгүй 116,163.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан, өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845.2 мянган төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй. Мөн төсөвт 6 байгууллагуудад жагсаалтаар олгосон 39,808.9 мянган төгрөгийн өртөг бүхий эко хавтан, замын хашлага, явган замын талаар хяналт тавьж хөрөнгийг бүртгэлд тусгуулаагүй, тус байгууллагуудтай хоорондын тооцоог хийгээгүй байна.

D:\2022-A4 тоот.docx

005020364

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.дахь "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байх", "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" "Толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГЫН АЖИРАГЧИЙН ХАМГААГАХ ХЭРЭГ" (State Audit Agency of Mongolia) and a central emblem. The signature is written in a cursive style, crossing the stamp.

Б.МӨНХБАТ

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>183,219,274.53</u>	<u>254,118,365.76</u>
АВЛАГА	10,135,000.00	9,980,000.00
Ажиллагчидтай холбогдсон авлага	155,000.00	00.00
Бусад авлага	9,980,000.00	9,980,000.00
Байгууллагаас авах авлага	9,980,000.00	9,980,000.00
БАРАА МАТЕРИАЛ	173,084,274.53	244,138,365.76
Түүхий эд материал	18,311,375.73	9,804,272.73
Тусгай зориулалттай материал	18,311,375.73	9,804,272.73
Дуусаагүй үйлдвэрлэл	805,500.00	1,076,000.00
Бэлэн бүтээгдэхүүн	3,250,000.00	9,250,000.00
Хангамжийн материал	149,667,398.80	224,008,093.03
Бичиг хэргийн материал	1,005,900.00	895,100.00
Аж ахуйн материал	65,549,032.00	87,222,773.03
Сэлбэг хэрэгсэл	4,800,700.00	11,238,220.00
Түлш, шатах тослох материал	1,615,666.80	00.00
Барилгын засварын материал	2,756,000.00	1,600,000.00
Бусад хангамжийн материал	73,940,100.00	123,052,000.00
Мал амьтад	1,050,000.00	00.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,231,618,898.86</u>	<u>14,543,103,912.32</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,231,618,898.86	14,543,103,912.32
Биет хөрөнгө	7,535,318,898.86	6,846,803,912.32
Барилга, байгууламж, орон сууц	548,228,618.13	548,228,618.13
Хуримтлагдсан элэгдэл	-439,023,484.50	-479,440,827.64
Авто-тээврийн хэрэгсэл	88,644,000.00	144,644,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-59,361,483.50	-68,085,883.58
Машин тоног төхөөрөмж (компьютер)	301,421,135.00	314,405,085.00
Хуримтлагдсан элэгдэл	-91,540,709.99	-145,794,497.56
Тавилга, аж ахуйн эд хогшил	14,077,200.00	14,077,200.00
Хуримтлагдсан элэгдэл	-8,611,829.62	-11,161,499.63
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000.00	800,000.00
Бусад үндсэн хөрөнгө	12,145,747,763.83	12,508,808,711.19
Хуримтлагдсан элэгдэл	-4,965,062,310.49	-5,979,676,993.59
Биет бус хөрөнгө	7,696,300,000.00	7,696,300,000.00
Програм хангамж	770,000.00	770,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
Бусад биет бус хөрөнгө	7,696,300,000.00	7,696,300,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,414,838,173.39</u>	<u>14,797,222,278.08</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>12,130,134.00</u>	<u>5,064,100.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,130,134.00	5,064,100.00
Өглөг	12,130,134.00	5,064,100.00
Ажилчидтай холбогдсон өглөг	117,034.00	00.00
Бусад өглөг	12,013,100.00	5,064,100.00
Байгууллагад төлөх өглөг	12,013,100.00	5,064,100.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>15,402,708,039.39</u>	<u>14,792,158,178.08</u>
Засгийн газрын хувь оролцоо	15,402,708,039.39	14,792,158,178.08
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,913,153,052.00	9,913,153,052.00

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өмч: - төрийн	9,913,153,052.00	9,913,153,052.00
Хуримтлагдсан үр дүн	5,487,669,673.80	4,877,119,812.49
Өмнөх үеийн үр дүн	5,487,669,673.80	5,487,669,673.80
Тайлант үеийн үр дүн	00.00	-610,549,861.31
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,885,313.59	1,885,313.59
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,414,838,173.39	14,797,222,278.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,871,741,565.88	1,572,546,960.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,204,826,775.88	644,782,390.39
120	Нийтлэг татварын бус орлого	1,204,826,775.88	644,782,390.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,204,826,775.88	1,652,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,439,000.00	1,652,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,198,387,775.88	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		438,121,197.36
122018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		205,008,893.03
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	666,914,790.00	927,764,570.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,289,253.00	22,544,970.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,289,253.00	22,544,970.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	542,191,400.00	817,942,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	542,191,400.00	817,942,300.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	90,424,100.00	87,277,300.00
1330	Төсвийн захирагчдаас	90,424,100.00	87,277,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,010,037.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,010,037.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,849,620,896.51	2,182,663,562.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,849,620,896.51	2,182,663,562.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,809,857,688.96	2,140,490,798.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,978,253.91	503,211,539.60
210101	Үндсэн цалин	321,978,253.91	503,211,539.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,166,036.75	75,812,380.73
210201	Тэтгэврийн даатгал	46,166,036.75	42,557,611.66
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	33,254,769.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,876,160.00	88,280,707.43
210301	Гэрэл, цахилгаан	56,929,600.00	86,525,647.43
210303	Цэвэр, бохир ус	946,560.00	1,755,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,328,696.99	46,211,975.85
210401	Бичиг хэрэг	2,914,900.00	3,495,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,728,333.20	14,146,666.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,258,463.79	1,527,777.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,887,000.00	5,434,000.00

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	00.00	20,907,732.00
2105	Нормативт зардал	18,281,000.00	3,640,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,281,000.00	3,640,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	109,450,322.50	50,317,824.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,132,800.00	2,975,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,591,000.00	6,733,500.00
210604	Урсгал засвар	94,726,522.50	40,608,824.19
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,847,508.00	32,366,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,948,544.00	31,422,620.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278,300.00	304,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	206,264.00	140,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	150,000.00
210807	Газрын төлбөр	64,400.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,929,710.81	1,340,649,751.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,880,620.00	201,190,426.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,067,049,090.81	1,139,459,325.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,763,207.55	42,172,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,270,737.00	42,136,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,010,037.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,940,700.00	23,506,309.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,320,000.00	18,629,991.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,492,470.55	36,464.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,492,470.55	36,464.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	22,120,669.37	-610,116,602.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	433,258.71
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	433,258.71
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-433,258.71
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,120,669.37	-610,549,861.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	673,353,790.00	929,571,870.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,439,000.00	1,807,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,439,000.00	1,807,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,439,000.00	1,807,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,439,000.00	1,807,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	666,914,790.00	927,764,570.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,289,253.00	22,544,970.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,289,253.00	22,544,970.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	632,615,500.00	905,219,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	542,191,400.00	817,942,300.00

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	90,424,100.00	87,277,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,010,037.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,010,037.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	670,353,790.00	916,315,470.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	670,353,790.00	916,315,470.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,590,582.45	874,142,706.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,745,491.66	506,027,354.33
210101	Үндсэн цалин	295,192,138.14	488,207,391.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,717,325.08	14,775,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,836,028.44	3,044,563.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,544,300.00	73,113,600.00
210201	Тэтгэврийн даатгал	33,819,800.00	56,066,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,181,100.00	3,409,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,386,000.00	2,727,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	795,100.00	681,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,362,300.00	10,228,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,876,160.00	88,280,707.43
210301	Гэрэл, цахилгаан	56,929,600.00	86,525,647.43
210303	Цэвэр, бохир ус	946,560.00	1,755,060.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,840,113.79	30,934,777.05
210401	Бичиг хэрэг	2,472,650.00	3,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,344,000.00	12,344,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,258,463.79	1,527,777.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,225,000.00	13,063,000.00
2105	Нормативт зардал	12,140,000.00	6,140,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,140,000.00	6,140,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,914,000.00	42,424,297.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	13,566,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,914,000.00	3,914,000.00
210604	Урсгал засвар	30,000,000.00	24,943,597.19
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,030,517.00	23,921,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114,131,553.00	22,977,970.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278,300.00	271,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	206,264.00	173,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	150,000.00
210807	Газрын төлбөр	64,400.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,500,000.00	103,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	103,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,763,207.55	42,172,764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,270,737.00	42,136,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,010,037.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,940,700.00	39,813,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,320,000.00	2,323,200.00

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,492,470.55	36,464.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,492,470.55	36,464.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,000,000.00	13,256,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	13,256,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	13,256,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	13,256,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000,000.00	13,256,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,000,000.00	-13,256,400.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	7,728,464,272.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	7,728,464,272.39
C07	Тайлант үеийн үр дүн	7,696,300,000.00	00.00	22,120,669.37	7,718,420,669.37
C08	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	5,487,669,673.80	15,402,708,039.39
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	5,487,669,673.80	15,402,708,039.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	5,487,669,673.80	15,402,708,039.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-610,549,861.31	-610,549,861.31
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	4,877,119,812.49	14,792,158,178.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**



Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	910,219,600.00	906,835,436.00	3,384,164.00	99.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	910,219,600.00	906,835,436.00	3,384,164.00	99.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,083,300.00	864,699,136.00	3,384,164.00	99.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,681,300.00	505,872,354.33	808,945.67	99.84
210101	Үндсэн цалин	488,861,300.00	488,052,391.33	808,908.67	99.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,775,400.00	14,775,400.00	-	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,044,600.00	3,044,563.00	37.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,113,600.00	73,113,600.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	56,066,900.00	56,066,900.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,409,300.00	3,409,300.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,727,500.00	2,727,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	681,900.00	681,900.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,228,000.00	10,228,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,171,800.00	88,280,707.43	891,092.57	99.00
210301	Гэрэл, цахилгаан	86,929,600.00	86,525,647.43	403,952.57	99.54
210303	Цэвэр, бохир ус	2,242,200.00	1,755,060.00	487,140.00	78.27
2104	Хангамж, бараа материалын зардал	31,180,200.00	30,934,777.05	245,422.95	99.21
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	3,300,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	12,344,000.00	12,344,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,773,200.00	1,527,777.05	245,422.95	86.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,063,000.00	13,063,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	6,140,000.00	6,140,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,140,000.00	6,140,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,914,000.00	55,680,697.19	233,302.81	99.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,000,000.00	26,823,100.00	176,900.00	99.34
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,914,000.00	3,914,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	24,943,597.19	56,402.81	99.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,582,400.00	1,377,000.00	1,205,400.00	53.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,490,000.00	433,000.00	1,057,000.00	29.06
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278,300.00	271,000.00	7,300.00	97.38

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	304,500.00	173,000.00	131,500.00	56.81
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,600.00	150,000.00	9,600.00	93.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103300000.00	103300000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,300,000.00	103,300,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42136300.00	42136300.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,136,300.00	42,136,300.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,813,100.00	39,813,100.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,323,200.00	2,323,200.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	910,219,600.00	906,835,436.00	3,384,164.00	99.63
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	905,219,600.00	905,183,136.00	36,464.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	817,942,300.00	817,905,836.00	36,464.00	100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	87,277,300.00	87,277,300.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	1,652,300.00	3,347,700.00	33.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	1,652,300.00	3,347,700.00	33.05
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	80.00	80.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	56.00	56.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	11.00	11.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,289,253.00	22,544,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,289,253.00	22,544,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,289,253.00	22,544,970.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,289,253.00	22,544,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,289,253.00	22,544,970.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,289,253.00	22,544,970.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,289,253.00	22,544,970.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,289,253.00	22,544,970.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
--	---	--	--

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор тохижилт үйлчилгээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор тохижилт үйлчилгээний газар нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилж хамгаалах, мод үржүүлэг ойжуулалт, ойн зурвасын харуул хамгаалалт, хотын доторх нийтийн эзэмшлийн хөшөө, түүх соёлын дурсгалт зүйл, парк, цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалт, хамгаалалт, усан оргилуур, усан толио зэрэг нийтийн эзэмшлийн усан байгууламжийн ашиглалт, явган хүний замын хавтан үйлдвэрлэл, гэрлэн дохионы засвар үйлчилгээ, арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээг хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Тус байгууллагын төсөв 2021 онд 910.2 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд тайлант оны гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 817.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 87.3 сая, өөрийн орлогоос 1.6 сая нийт 906.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны ээлжит бус IV хуралдааны 4/15 дугаартай тогтоолоор тус байгууллагын төсөвт өөрчлөлт оруулж 880.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2021 оны А/125 дугаартай захирамжаар бүтэц, орон тоог үндсэн- 69, гэрээт-11 нийт 80 ажилтантайгаар баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд боловсруулсан “Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,892,787.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,391.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 18,454.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,182,663.6 мянган төгрөгөөс тооцоход 21,281.0 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 617,615.9 мянган төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	183,219.3	254,118.4	70,899.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	10,135.0	9,980.0	(155.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	173,084.3	244,138.4	71,054.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,231,618.9	14,543,103.9	(688,515.0)
Үндсэн хөрөнгө	20,795,988.7	21,228,033.6	432,044.9
Хуримтлагдсан элэгдэл	(5,564,369.8)	(6,684,929.7)	(1,120,559.9)
Нийт хөрөнгө	15,414,838.2	14,797,222.3	(617,615.9)
Өр төлбөр	12,130.1	5,064.1	(7,066.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,402,708.0	14,792,158.2	(610,549.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,414,838.2	14,797,222.3	(617,615.9)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 9,980.0 мянган төгрөг болж 155.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагаас 155.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг барагдуулсантай холбоотой байна.

Мөн авлагын үлдэгдэл 9980.0 мянган төгрөг нь ажилчдын орон сууцны зураг төсвийн үнэ болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 244,138.3 мянган төгрөг болж 71,054.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 179,607.3 мянга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй олгосон 116,163.7 мянга, өөрөө үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүн 88,845.2 мянга, нийт 384,616.2 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, байгууллагын даргын 2021.12.28-ны өдрийн А/165 дугаартай тушаалаар 20,907.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 292,654.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 21,228,033.6 мянган төгрөг болж 432,044.9 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 13,256.4 мянга, аймгийн ИТХТ-дийн 2021 оны 91 дүгээр тогтоолоор Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газраас шилжиж ирсэн автомашин 52,000.0 мянга, аймгийн ИТХТ-дийн 2021 оны “Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 02, 27, 115 дугаар тогтоол, Баянхонгор сумын ИТХТ-дийн 2020 оны 09 дүгээр тогтоолуудын дагуу үнэ төлбөргүй хүлээн авсан 382,121.2 мянга, аймгийн Засаг даргаас хандивласан мотоцикл 4,000.0 мянга, нийт 451,377.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 116 дугаартай тогтоолын дагуу 19,332.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өмнөх оны цалингийн зардалтай холбоотой 117.0 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулж, модны суулгац нийлүүлэх тендерт 2020 онд оролцож шалгарсан Оюунлаг хонгорчууд ТББ-д төлөх 12,013.1 мянган төгрөгийн өглөгөөс 6,949.0 мянган төгрөгийг шилжүүлж 5,064.1 мянган төгрөгийн өрийг барагдуулаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,792.1 мянган төгрөг болж 610,549.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 858,805.6 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 198,011.6 мянган төгрөгөөр бууруулж 660,794.0 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн ээлжит бус IV хуралдааны 4/15 дугаартай тогтоолоор өөрийн орлогын төлөвлөгөөг 5,000.0 мянга, зардлыг 880,219.6 мянган төгрөгөөр, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/742 дугаартай тогтоолоор 30,000.0 мянган төгрөг нийт 910,219.6 мянган төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 817,942.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 87,277.3 мянга, өөрийн орлогоос 5,000.0 мянга, нийт 910,219.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 817,942.3 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас байгаль орчныг нөхөн сэргээх зардал 87,277.3 мянга, өөрийн орлогоос 1,652.3 мянга, нийт 906,835.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 906,835.4 мянган төгрөгийг зарцуулж 36.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 906,835.4 мянган төгрөг буюу 99.6 % хувьтай байгаа нь цалингийн зардлаас 808.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 891.1 мянга, хангамж бараа материалын зардал 245.4 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 233.3 мянга, төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,205.4 мянга, нийт 3,384.1 мянган төгрөгийг хэмнэж, өөрийн орлогыг 3,347.7 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т хөрөнгө зарцуулах тухай ” А/624 дугаартай захирамжаар нөөц хөрөнгөнөөс 10,545.0 мянга, аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн “Хөрөнгө зарцуулах тухай” А/466 дугаартай захирамжаар нөөц хөрөнгөнөөс 12,000.0 мянга нийт 22,545.0 мянган санхүүжилтийг олгож, хавтангийн тоног төхөөрөмж угсрах ажлын хөлсөнд 12,000.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 10,545.0 мянга, нийт 22,545.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 45 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тус байгууллага нь тайлант онд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлтийн ажилд 47 иргэнийг ажиллуулж ажиллагсдын цалинд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон 102,999.0 мянган төгрөгийг олгосон.

2021 оны 06 дугаар сард явган замын хавтангийн үйлдвэр угсарч ашиглалтад оруулсан бөгөөд, хандиваар ирсэн 140 тонн цементээр 11690 ширхэг эко хавтан, 5484 ширхэг бродюр, 1782м² явган замыг тус тус үйлдвэрлэсэн байна.

Дээрх үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс Чандмань Баянхонгор ХК, аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Музей, Баянхонгор сумын ЗДТГ, Татварын хэлтэс зэрэг нийт 6 газарт 39,808.9 мянган төгрөгийн 5664 ширхэг эко хавтан, 1186 ширхэг замын хашлага, 922,14м² явган замын хавтанг шийдвэр гараагүй байхад үнэ төлбөргүй олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,182,941.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 289,875.8 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор тохижилт үйлчилгээний газар нь 2021 онд 1,172,211.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 998,525.5 мянган төгрөгийн 111 мэдээллийг хугацаандаа байршуулж 173,685.6 мянган төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	29	7	
5	Тухай бүр	8	96	58	38	
	Нийт	27	151	101	48	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант онд 910,219.6 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 906,835.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 204,308.4 мянган төгрөгөөс 10 хувь болох 20,430.8 мянган төгрөг хэмнэхээс 36,4 мянган төгрөгийг хэмнэж 20,394.4 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 89,171.8 мянган төгрөгөөр баталж 88,280.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 17,834.4 мянган төгрөг хэмнэхээс 891.1 мянган төгрөгийн хэмнэлт гарган 16,943.3 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 404,156.9 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 28,865.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 353,026.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага 22,265.1 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлснийг өгсөн бөгөөд хэрэгжилтийг Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021.06.17-ны өдрийн 80 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022.02.09-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай" А/59 дугаартай захирамжаар, 6409007812 нэгж талбарын дугаар

бүхий нийтийн орон сууцны зориулалттай 644м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон тул өмнөх оны зураг төсвийн үнэ болох 9980.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа. материалын дансанд үнэ төлбөргүй орлого авсан 116,163.7 мянган төгрөгийн хөрөнгийн бэлтгэн нийлүүлэгчийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сан гэж бүртгэсэн бөгөөд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээ, төлбөрийг шилжүүлсэн эсэх нь тодорхойгүй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзэж байна

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 250,117.8 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 213,494.5 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 36,623.3 мянган төгрөгийн зөрчил давтан гаргахгүй байх 5 алдаанд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” төсөвт үйлдвэрийн газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон хэлбэрийг өөрчилж, дүрмийг баталсан байтал тайлант онд тус байгууллага нь орон нутгийн төсвөөс 906,835.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Мөн тогтоолын 4 дүгээр заалтад “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоог баталж, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байтал тус байгууллагын бүтэц орон тоог Засаг дарга батлаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2. Аж ахуйн нэгж байгууллага жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2. “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоог баталж, цаашид “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллуулж, төсвөөс санхүүгийн дэмжлэг олгохгүй байх арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Баянхонгор тохижилт үйлчилгээний газар нь 2021 онд 1,172,211.1 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 998,525.5 мянган төгрөгийн 111 мэдээллийг хугацаандаа байршуулж 173,685.6 мянган төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын код **БНА-2022/17/НА-СТА-ТШЗ**

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

3. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч нь тодорхойгүй 116,163.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан, өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845.2 мянган төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй. Төсөвт 6 байгууллагуудад жагсаалтаар олгосон 39,808.9 мянган төгрөгийн өртөг бүхий эко хавтан, замын хашлага, явган замын талаар хяналт тавьж хөрөнгийг бүртгэлд тусгуулаагүй, тус байгууллагуудтай хоорондын тооцоог хийгээгүй байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.дахь "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байх", "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" "Толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тухайн байгууллага нь өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845,200 төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэж, төсөвт байгууллагуудад олгосон 39,808,900 төгрөгийн материалын тооцоог хэрхэн хийх шийдвэр гаргуулан, баримтжуулан холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4.2. Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.01.18-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор эзэмшигч тогтоосон 19,680.0 мянган төгрөгийн ойн зурвасны хамгаалалтын хайс, тулгуур шонг орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.дахь "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байх", "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгаль орчны нөхөн сэргээх зардлаар хийгдсэн ойн зурвасын 19,680.0 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас актаар хүлээн авч бүртгэлд тусгах.

2. Тус байгууллага нь 2021.08.25-ны өдөр эко хавтангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрах ажлын хөлс 12,00.0 мянган төгрөгөөс 4,350.0 мянган төгрөгийг Базардарь ХХК-д, 7,650.0 мянган төгрөгийг Зэвсэгт хүчний 339-р ангид шилжүүлсэн бөгөөд ажлын хөлсийг хоорондын тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ЗААВАР"-ын Өглөгийн бүртгэл 4.60 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" Өглөгийн бүртгэл 4.60 дахь заалтыг мөрдөж ажиллах, алдааг дахин давтахгүй байх.

3.Нягтлан бодогч санхүүгийн программд бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн./ 1ш явган замын хавтанд 939 төгрөгөөр өртөг тооцсон байтал 1ш-ийг 15.0 мянган төгрөгөөр, 1ш цементийг 300.0 мянган төгрөгөөр орлого авсан байна. Мөн нярав бараа материалын тайлан гаргахдаа хөрөнгийн зарцуулалтыг гаргахдаа зарлагын баримт бичдэггүй шууд шаардах хуудсаар зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Иж бүрэн байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Бараа материалын тайланг гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэдэг алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

4. Тус байгууллага нь тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 89,171.8 мянган төгрөгөөр баталж 88,280.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 17,834.4 мянган төгрөг хэмнэхээс 891.1 мянган төгрөгийн хэмнэлт гарган 16,943.3 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

5.Төсвийн хөрөнгөөр 13,256.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн бөгөөд нягтлан бодогч гүйлгээ хийхдээ хөрөнгийн зардлын сонголт хийгээгүйгээс мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгийн зардал буруу илэрхийлэгдсэн, мөн санхүүгийн байдлын тайлангийн бусад үндсэн хөрөнгийн дүн, үндсэн хөрөнгийн тайлангийн бусад үндсэн хөрөнгийн дүнгүүд 395.1 мянган төгрөгөөр тус тус зөрсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "бодитой оршин байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид алдаа зөрчил дахин гаргахгүй байх зөвлөмж өгөх

Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	6	59,488.9					2	39,808.9	4	19,680.0
	Дүн	6	59,488.9					2	39,808.9	4	19,680.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Шилэн данс	1	173,685.6					1	173,685.6		
2	ЗГ-ын 43 дугаар тогтоол	1	16,943.3							1	16,943.3
	Дүн	2	190,628.9					1	173,685.6	1	16,943.3
	НИЙТ ДҮН	8	250,117.8					3	213,494.5	5	36,623.3

оОо



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 86/A0570643/БНА
2022/17/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч нь тодорхойгүй 116,163,693 төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авсан.

Тухайн байгууллага нь өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845,200 төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгээгүй. Үүнээс төсөвт 6 байгууллагуудад жагсаалтаар 39,808,900 төгрөгийн өртөг бүхий эко хавтан, замын хашлага, явган замын олгосон ч шийдвэр гаргаагүй тус байгууллагуудтай хоорондын тооцоог хийгээгүй, хөрөнгийг бүртгэлд тусгуулаагүй, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.дахь "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", санхүүгийн тайлангийн "Бодитой оршин байх", "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" "Толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 дэх " Нягтлан

d:\2022.албан шаардлага.docx

• 005040225

бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тухайн байгууллага нь өөрсдөө үйлдвэрлэсэн 88,845,200 төгрөгийн эко хавтан, явган зам, замын хашлага зэргийг аж ахуйн материалын дансанд бүртгэснийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд шилжүүлэн бүртгэж, төсөвт байгууллагуудад олгосон 39,808,900 төгрөгийн материалын тооцоог хэрхэн хийх шийдвэр гаргуулан, баримтжуулан холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт хариуцуулав².

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН³:
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ
АУДИТОР Л.ДОРЖХАНД



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 84/А0570643/БНА
2022/17/НА - СТА - ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” төсөвт үйлдвэрийн газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон хэлбэрийг өөрчилж, дүрмийг баталж, тайлант онд тус байгууллага нь орон нутгийн төсвөөс 906,835,436 төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Мөн тогтоолын 4 дүгээр заалтад “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоог баталж, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан байтал тус байгууллагын бүтэц орон тоог Засаг дарга батлаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2. Аж ахуйн нэгж байгууллага жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2. “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дугаар тогтоолын 4 дүгээр заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн,

d:\2022.албан шаардлага.docx

• 005040226

хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 дэх “ хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж “Баянхонгор-Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоог баталж, цаашид “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллуулж, төсвөөс санхүүгийн дэмжлэг олгохгүй байх арга хэмжээ авах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт⁴ ирүүлэхийг аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт хариуцуулав⁵.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН ⁶:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТОР

Л.ДОРЖХАНД

6417143544
БНӨА0067 9007423

⁴ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

⁵ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

⁶ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 88/А0570543/БНА
2022/17/НА-СТА-ТЦЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор тохижилт үйлчилгээний газар нь 2021 онд 1,172,211,117 төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 998,525,467 төгрөгийн 111 мэдээллийг хугацаандаа байршуулж 173,685,650 төгрөгийн 48 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 дэх " хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллээс 173,685,650 төгрөгийн 48 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаа

d:\2022.албан шаардлага.docx


005040231

хоцроож байршуулсан бөгөөд мэдээллийг цаашид хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт⁷ ирүүлэхийг Баянхонгор тохижилт үйлчилгээний газрын дарга Т.Отгонбаатар, нягтлан бодогч Б.Болормаа нарт хариуцуулав⁸.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН 9:
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР	А.ЦЭЭНЯМ
АУДИТОР	Л.ДОРЖХАНД



⁷ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

⁸ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

⁹ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно